

## **АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, УЛСЫН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь автотээврийн хэрэгслийн өмчлөх эрх болон бүртгэл хөтлөх, улсын бүртгэлийн дугаар олгох, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу гүйцэтгэх ажлын зориулалтаар ашиглаж байгаа болон **төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан албан тушаалтан, иргэн**, Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэргийн, онцгой байдлын албаны автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа нь энэхүү журамд хамаарахгүй.

1.3. Автотээврийн хэрэгслийг бүртгэхдээ “Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томьёо, тодорхойлолт” MNS ISO 3833:2010 стандартыг баримтална.

### **Хоёр. Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх**

2.1. Бүртгэлийн байгууллага нь автотээврийн хэрэгслийн өмчлөх эрхийн болон ашиглалттай холбоотой бүртгэлийг холбогдох хууль тогтоомж, энэхүү журамд нийцүүлэн хөтөлнө.

2.2. Автотээврийн хэрэгслийн бүртгэл нь дараах төрөлтэй байна:

2.2.1. автотээврийн хэрэгслийг шинээр бүртгэх;

2.2.2. автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн;

2.2.3. автотээврийн хэрэгслийн техникийн өөрчлөлт;

2.2.4. автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээг нөхөн олгох;

2.2.5. автотээврийн хэрэгслийн бүртгэлээс хасах, бүртгэлийг сэргээх;

2.2.6. автотээврийн хэрэгсэлд түр дугаар олгох;

2.2.7. автотээврийн хэрэгслийн улсын дугаарын өөрчлөлт, солилт;

2.2.8. **автотээврийн хэрэгслийн улсын дугаарын хадгалах;**

### **Гурав. Автотээврийн хэрэгслийг шинээр бүртгэх**

3.1. Импортоор оруулж ирсэн болон Монгол Улсад үйлдвэрлэсэн автотээврийн хэрэгслийг мэдээллийн санд шинээр бүртгэнэ.

3.2. Шинээр бүртгэсэн автотээврийн хэрэгсэлд улсын бүртгэлийн дугаар, автотээврийн хэрэгслийн гэрчилгээ олгоно.

3.3. Монгол улсын иргэн автотээврийн хэрэгслийг шинээр бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

3.3.1 үнэн зөв мэдүүлсэн бүртгэлийн мэдүүлэг;

3.3.2 иргэний үнэмлэх;

3.3.3. гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг;

3.3.4 импортоор оруулж ирсэн шинэ болон ашиглагдаж байсан автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн, эсхүл экспортын дагалдах баримт бичиг;

3.3.5. Монгол Улсын Иргэний хуульд заасан өмчлөх эрх шилжүүлэх бүх төрлийн гэрээ;

3.3.6 техникийн хяналтын үзлэгт тэнцэж, мэдээлэл зөрүүгүй байх;

3.3.7 улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ, үйлчилгээний хөлс төлсөн баримт;

3.3.8. тусгай тоноглол суурилагдсан автотээврийн хэрэгслийн хувьд нэмэлт төхөөрөмжийн техникийн байдлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар шалгуулж баталгаажуулсан дүгнэлт;

3.3.9. Монгол Улсад үйлдвэрлэсэн автотээврийн хэрэгслийн хувьд тохирлын болон техникийн гэрчилгээ, автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар /VIN code/ олгосон тухай баталгаажуулсан баримт;

3.4. Хуулийн этгээд автотээврийн хэрэгслийг шинээр бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.4.1. албан хүсэлт;

3.4.2. нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээ;

3.4.3.энэхүү журмын 3.3.1, 3.3.3-3.3.9-д заасан баримт бичиг

3.5. Дипломат байгууллага нь автотээврийн хэрэгслийг шинээр бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.5.1.гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хүсэлт;

3.5.2.энэхүү журмын 3.3.1, 3.3.4-3.3.9-д заасан баримт бичиг;

3.6. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага нь автотээврийн хэрэгсэлийг шинээр бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

3.6.1. төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэр

3.6.2. энэхүү журмын 3.3.1, 3.3.3-3.3.9, 3.4-д заасан баримт бичиг;

3.7. Монгол Улсад байнга оршин суугаа болон түр оршин суух гадаадын иргэний автотээврийн хэрэгсэлийг шинээр бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

3.7.1. оршин суух үнэмлэх;

3.7.2. энэхүү журмын 3.3.1, 3.3.3-3.3.9-д заасан баримт бичиг;

3.8. Энэхүү журмын 3.3.3, 3.3.4-д заасан баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагаас авсан хуулбар лавлагаа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулж хүчингүй болсонд тооцуулсан, баримт бичгийг тус тус үндэслэн бүртгэнэ.

3.9. Гаалийн түр болон буцах горимоор орж ирсэн тээврийн хэрэгслийг горим үйлчлэх хугацаанд бусдад шилжүүлэхийг хориглоно.

3.10. Гэрчилгээ, улсын дугаар олгогдсон боловч бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдээгүй тээврийн хэрэгслийг энэхүү журмын 3.3.1, 3.3.2, 3.3.6, 3.3.8 3.4 дэх заалт, архивын холбогдох баримт бичгийг тус тус үндэслэн шинээр бүртгэнэ.

**3.11. Автотээврийн хэрэгслийн техникийн үзүүлэлтийг техникийн хяналтын үзлэгийн мэдээлэлд үндэслэн бүртгэнэ.**

#### **Дөрөв. Автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний бүртгэл**

4.1. Шилжүүлж буй өмчлөгчөөс олгосон эрх, түүний ирүүлсэн хүсэлтийн дагуу тухайн автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэнэ.

4.2. Монгол улсын иргэн автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

4.2.1. үнэн зөв мэдүүлсэн бүртгэлийн мэдүүлэг;

4.2.2. автотээврийн хэрэгслийн гэрчилгээ

4.2.3. иргэний үнэмлэх

4.2.4. техникийн хяналтын үзлэгт хамрагдсан, мэдээлэл зөрүүгүй байх;

4.2.5. автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн тухайн жилийн албан татвар төлсөн байх;

4.2.6. хуулийн дагуу ногдуулсан торгуулийг төлсөн байх;

4.2.7. улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ, үйлчилгээний хөлс төлсөн баримт;

4.2.8. автотээврийн хэрэгслийн өмчлөлийг шилжүүлж буй иргэн өөрийн биеэр байх, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн гэрээ, хэлцэл Монгол Улсын Иргэний хуульд заасан өмчлөх эрх шилжүүлэх бүх төрлийн гэрээ

4.3. Хуулийн этгээд автотээврийн хэрэгсэлийн шилжилт хөдөлгөөнийг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

4.3.1. албан хүсэлт,

4.3.2. нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээ

4.3.3. энэхүү журмын 4.2.1, 4.2.2, 4.2.4-4.2.8-д заасан баримт бичиг;

4.4. Дипломат байгууллага автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

4.4.1. гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хүсэлт;

4.4.2. энэхүү журмын 4.2.1-4.2.2, 4.2.4-4.2.7-д заасан баримт бичиг;

4.5. Монгол Улсад байнга оршин суугаа болон түр оршин суух гадаадын иргэний автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

4.5.1. оршин суух үнэмлэх;

4.5.2. энэхүү журмын 4.2.1-4.2.2,4.2.4-4.2.8-д заасан баримт бичиг;

4.6. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.Үүнд:

4.6.1. төрийн болон орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэр,

4.6.2. шилжүүлэн авсан болон шилжүүлэн өгсөн байгууллагын албан хүсэлт;

4.6.3.энэхүү журмын 4.2.1-4.2.2, 4.2.4-4.2.8-д заасан баримт бичиг;

4.7. Өмчлөх эрхийг шилжүүлсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэн бүртгэл хийнэ.

4.8. Татан буугдсан хуулийн этгээдийн автотээврийн хэрэгслийг хуульд заасан эрх бүхий этгээдийн шийдвэр болон улсын бүртгэлийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн өмчлөгчийг шинэчлэн шилжүүлж бүртгэнэ.

4.9. Автотээврийн хэрэгслийн өмчлөгч иргэн нас барсан тохиолдолд өвлөх эрхийн гэрчилгээг үндэслэн өвлөгчийн нэр дээр шилжүүлэн бүртгэнэ.

4.10. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр автотээврийн хэрэгслийг бусдын өмчлөлд шилжүүлэхийг хязгаарласан, цуцалсан, эсхүл баталгаажуулсан бол уг шийдвэрийг үндэслэн бүртгэж мэдээллийн санд оруулна.

4.11. Монгол Улсын Иргэний хуульд зааснаар өмчлөх эрх шилжүүлэх гэрээ байгуулагдсан тохиолдолд тээврийн хэрэгслийн гэрчилгээг үрэгдүүлснийг үл харгалзан энэ журмын холбогдох заалтад заасан баримт бичгийг үндэслэн шилжилт хөдөлгөөнийг бүртгэнэ.

#### **Тав. Автотээврийн хэрэгслийн техникийн өөрчлөлтийн бүртгэл**

5.1. Автотээврийн хэрэгслийн техникийн өөрчлөлтөд дараах өөрчлөлтүүд хамаарна. Үүнд:

5.1.1.автотээврийн хэрэгслийн зориулалтын өөрчлөлт;

5.1.2. өнгөний өөрчлөлт

5.1.3. хөдөлгүүрийн өөрчлөлт

5.1.4. арлын өөрчлөлт

5.1.5. бүхээгийн өөрчлөлт

5.2. Тухайн автотээврийн хэрэгслийн зориулалтыг зөвхөн үйлдвэрлэгчийн зөвшөөрлөөр өөрчлөх ба үйлдвэрлэгчээс эрх олгогдсон засварын байгууллагаар хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.

5.3. Монгол Улсын иргэн техникийн өөрчлөлтийг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.Үүнд:

- 5.3.1. үнэн зөв мэдүүлсэн бүртгэлийн мэдүүлэг;
  - 5.3.2. автотээврийн хэрэгслийн гэрчилгээ;
  - 5.3.3. иргэний үнэмлэх;
  - 5.3.4. техникийн хяналтын үзлэгт хамрагдсан, мэдээлэл зөрүүгүй байх;
  - 5.3.5. автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн тухайн жилийн албан татвар төлсөн байх;
  - 5.3.6. хуулийн дагуу ногдуулсан торгуулийг төлсөн байх;
  - 5.3.7. улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ, үйлчилгээний хөлс төлсөн баримт;
  - 5.3.8 техникийн өөрчлөлт нь стандартын шаардлага хангаж байгааг нотолсон магадлан итгэмжлэгдсэн байгууллагын техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт;
  - 5.3.9 арал, бүхээг өөрчлөгдсөн бол гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг, бусад баримт бичиг;
- 5.4. Хуулийн этгээд техникийн өөрчлөлтийг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:
- 5.4.1. албан хүсэлт,
  - 5.4.2. нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээ
  - 5.4.3. энэхүү журмын 5.3.1-5.3.2, 5.3.4-5.3.9-д заасан баримт бичиг;
- 5.5. Автотээврийн хэрэгслийн техникийн өөрчлөлтийн бүртгэл хийгдсэн тээврийн хэрэгслийн улсын дугаар өөрчлөгдөхгүй хэвээр байна.

### **Зургаа. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээг нөхөн олгох**

- 6.1. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг дараах тохиолдолд сольж нөхөн олгоно. Үүнд:
- 6.1.1. Цаашид ашиглах боломжгүй болсон;
  - 6.1.2. Хаяж, үрэгдүүлсэн;
- 6.2. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгоход Монгол Улсын иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:
- 6.2.1. үнэн зөв мэдүүлсэн бүртгэлийн мэдүүлэг;
  - 6.2.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчингүй болгох тухай зарлуулсан баримт;
  - 6.2.3. иргэний үнэмлэх
  - 6.2.4. техникийн хяналтын үзлэгт хамрагдсан, мэдээлэл зөрүүгүй байх;
  - 6.2.5. автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн тухайн жилийн албан татвар төлсөн байх;
  - 6.2.6. Хуулийн дагуу ногдуулсан торгуулийг төлсөн байх;
  - 6.2.7. Улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ, үйлчилгээний хөлс төлсөн баримт.

6.3. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгоход хуулийн этгээд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

6.3.1. албан хүсэлт,

6.3.2. нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээ

6.3.3. энэхүү журмын 6.1.1-6.1.2, 6.1.4-6.1.7-д заасан баримт бичиг;

6.4. Дипломат байгууллага автотээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

6.4.1. гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хүсэлт;

6.4.2. энэхүү журмын 6.1.1-6.1.2, 6.1.4-6.1.7-д заасан баримт бичиг;

6.5. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага нь автотээврийн хэрэгсэлийг гэрчилгээг нөхөн олгоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

6.5.1. төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэр;

6.5.2. энэхүү журмын 6.1.1-6.1.2, 6.1.4-6.1.7-д заасан баримт бичиг;

6.6. Монгол Улсад байнга оршин суугаа болон түр оршин суух гадаадын иргэний автотээврийн хэрэгслийг шинээр бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

6.6.1. оршин суух үнэмлэх;

6.6.2. энэхүү журмын 6.1.1-6.1.2, 6.1.4-6.1.7-д заасан баримт бичиг;

6.7. Улсын бүртгэлийн дугаарыг дараах тохиолдолд нөхөн олгоно. Үүнд:

6.7.1. цаашид ашиглах боломжгүй болсон;

6.7.2. хаяж, үрэгдүүлсэн;

6.8. Улсын бүртгэлийн дугаарыг нөхөн олгох тохиолдолд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг үндэслэн нөхөн олгоно.

6.9. Цаашид ашиглах боломжгүй болсон автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын бүртгэлийн дугаарыг өмчлөгчийн хүсэлтээр энэ журмын 6.2.2-т зааснаас бусад баримт бичгийг үндэслэн сольж олгоно.

6.10. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр автотээврийн хэрэгслийг бусдын өмчлөлд шилжүүлэхийг хязгаарласан тохиолдолд шийдвэр гаргасан байгууллагын зөвшөөрлийг үндэслэн нөхөх болон сольж олгоно.

### **Долоо. Автотээврийн хэрэгслийн бүртгэлээс хасах, бүртгэлийг сэргээх**

7.1. Автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасахад дараах тээврийн хэрэгсэл хамрагдана. Үүнд:

7.1.1. ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгсэл;

7.1.2. Монгол Улсад ашиглагдаж байгаад экспортод гарсан автотээврийн хэрэгсэл;

7.2. Дараах тохиолдолд бүртгэлийн байгууллага автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасна. Үүнд:

7.2.1. эрх бүхий хуулийн байгууллагын шийдвэр гарсан байх;

7.2.2. тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч тогтоогдохгүй байх;

7.2.3. сүүлийн 5 жил техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй;

7.2.4. Бүртгэлийн байгууллага энэ журмын 7.2.2, 7.2.3 заасан үндэслэлээр хасалт хийх тохиолдолд нэг сарын өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлсэн байна.

7.3. Автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасуулахад иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

7.3.1. үнэн зөв мэдүүлсэн бүртгэлийн мэдүүлэг;

7.3.2. иргэний үнэмлэх

7.3.3. хуулийн дагуу ногдуулсан торгуулийг төлсөн байх;

7.3.4. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн тухайн жилийн албан татвар төлсөн байх;

7.3.5. үйлчилгээний хөлс төлсөн баримт.

7.3.6. автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарын тэмдэг үрэгдүүлсэн бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлуулсан баримт;

7.3.7. автотээврийн хэрэгслийг дахин боловсруулах үйлдвэрт тушаасан бол тухайн үйлдвэрийн тодорхойлолт.

7.4. Автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасахад хуулийн этгээд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

7.4.1. албан хүсэлт,

7.4.2. нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээ

7.4.3. энэхүү журмын 7.3.1, 7.3.3-7.3.7-д заасан баримт бичиг

7.5. Дипломат байгууллага автотээврийн хэрэгслийн бүртгэлээс хасахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

7.5.1. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хүсэлт;

7.5.2. Энэхүү журмын 7.3.1, 7.3.3-7.3.7-д заасан баримт бичиг;

7.6. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага нь автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

7.6.1. төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэр;

7.6.2. энэхүү журмын 7.3.1, 7.3.3-7.3.7-д заасан баримт бичиг;

7.7. Монгол Улсад байнга оршин суугаа болон түр оршин суух гадаадын иргэний автотээврийн хэрэгслийг бүртгэлээс хасахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

7.8.1. оршин суух үнэмлэх;

7.8.2. энэхүү журмын 7.3.1, 7.3.3-7.3.7-д заасан баримт бичиг;

7.9. Бүртгэгч нь бүртгэлийн мэдүүлэг, баримт бичгийг үндэслэн бүртгэлээс хасагдсан авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарын тэмдгийг хураан авч, мэдээллийн санд бүртгэн, тодорхойлолтыг өмчлөгчид олгоно.

7.10. Дараах тохиолдолд хасагдсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг сэргээнэ. Үүнд:

7.10.1. өмчлөгчийн хүсэлт;

7.10.2. тээврийн хэрэгсэл нь стандартын шаардлага хангасан тухай техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт;

7.10.3. Тухайн жилийн татвар төлөгдсөн байх;

### **Найм. Автотээврийн хэрэгсэлд түр дугаар олгох**

8.1. Автотээврийн хэрэгсэлд түр дугаарыг дараах тохиолдолд олгоно.

8.1.1. экспортод гаргах зорилгоор автотээврийн хэрэгслийн бүртгэлээс хасагдсан тээврийн хэрэгсэлд “Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг: ерөнхий шаардлага”. MNS 4410-1:2002<sup>1</sup> стандартын D хавсралтын 4 дэх зурагт заасан загварын хүрээнд түр дугаарыг олгоно.

8.1.2. автотээврийн хэрэгсэл худалдаалах албан ёсны эрх бүхий байгууллагын худалдан борлуулахаар импортоор оруулж ирсэн шинэ автотээврийн хэрэгсэлд гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэгт үндэслэн үзэсгэлэн худалдаанд оролцох, агуулах хүрэх, техникийн хяналтын үзлэгт хамрагдах зорилгоор авто замын хөдөлгөөнд оролцох үед түр дугаар олгоно.

8.2. Түр дугаарыг 1 сар хүртэл хугацаагаар олгоно.

8.3. Автотээврийн хэрэгсэл худалдаалах албан ёсны эрх бүхий байгууллагын албан хүсэлт, гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэг, улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн 8.1.2 -т заасан дугаарыг олгоно.

8.4. Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа автотээврийн хэрэгсэлд түр дугаар олгох зохицуулалтыг Замын хөдөлгөөний тухай конвенцийн дагуу шийдвэрлэнэ.

8.5. Замын хөдөлгөөний тухай конвенцид нэгдэн ороогүй улсын автотээврийн хэрэгсэлд түр дугаар олгох асуудлыг Засгийн газрын хооронд байгуулсан тээврийн хэлэлцээрийн дагуу шийдвэрлэнэ.

8.6. Энэхүү журмын **8.1.2 дахь** хэсэгт заасан түр дугаарыг “Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг: ерөнхий шаардлага”. MNS 4410-1:2002<sup>1</sup> стандартын D хавсралтын 4 дэх зургийн “Transit” гэдгийн оронд албан ёсны борлуулагчийн нэр, “дугаарын оронд автотээврийн хэрэгслийн арлын дугаарыг бичиж олгоно.

8.7. Түр дугаарыг 210 граммаас доошгүй жинтэй цаасан дээр хэвлэн олгоно.

### **Ес. Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын өөрчлөлт, солилт**

9.1. Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлийн дугаарыг өөрчлөх, солих тохиолдолд Монгол Улсын иргэн дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

9.1.1. үнэн зөв мэдүүлсэн бүртгэлийн мэдүүлэг;

9.1.2. иргэний үнэмлэх

9.1.3. техникийн хяналтын үзлэгт хамрагдсан, мэдээлэл зөрүүгүй байх;



- 9.1.4. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн тухайн жилийн албан татвар төлсөн байх;
- 9.1.5. хуулийн дагуу оногдуулсан торгуулийг төлсөн байх;
- 9.1.6. улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ,
- 9.1.7. үйлчилгээний хөлс төлсөн баримт;
- 9.1.8. улсын бүртгэлийн дугаарыг солих бол тээврийн цагдаагийн албанаас хэрэг зөрчилд холбогдоогүй тухай тодорхойлолт; **/судлах/**
- 9.2. Улсын бүртгэлийн дугаарыг өөрчилж, сольсон, хадгалах тохиолдолд өмнөх улсын бүртгэлийн дугаарын тэмдгийг хураан авна.
- 9.3. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг өөрчлөх, солих тохиолдолд хуулийн этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
- 9.2.1. албан хүсэлт,
- 9.2.2. нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээ
- 9.2.3. Энэхүү журмын 9.1.1, 9.1.3-9.1.8-д заасан баримт бичиг;
- 9.4. Дипломат байгууллага автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг өөрчлөх, солих тохиолдолд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
- 9.4.1. гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хүсэлт;
- 9.4.2. энэхүү журмын 9.1.1, 9.1.3-9.1.8-д заасан баримт бичиг;
- 9.5. Монгол Улсад байнга оршин суугаа болон түр оршин суух гадаадын иргэний автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг өөрчлөх, солих тохиолдолд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
- 9.4.1. оршин суух үнэмлэх;
- 9.4.2. энэхүү журмын 9.1.1, 9.1.3-9.1.8-д заасан баримт бичиг;
- 9.6. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлийн дугаарыг өөрчлөх, солих тохиолдолд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
- 9.6.1. төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын шийдвэр,
- 9.6.2. шилжүүлэн авсан болон шилжүүлэн өгсөн байгууллагын албан хүсэлт;
- 9.6.3. Энэхүү журмын 9.1.1, 9.1.3-9.1.8-д заасан баримт бичиг;
- 9.7. Улсын бүртгэлийн дугаарыг өмчлөгчийн хүсэлтээр тухайн оршин суух засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу сольж, өөрчилнэ.
- 9.8. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр автотээврийн хэрэгслийг бусдын өмчлөлд шилжүүлэхийг хязгаарласан тохиолдолд улсын бүртгэлийн дугаарыг өөрчлөх, солих бүртгэл хийхийг хориглоно.

#### **Арав. Автотээврийн хэрэгслийн улсын дугаар хадгалах**

- 10.1. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн өмчлөгч нь улсын бүртгэлийн дугаараа хадгалуулах хүсэлт гаргаж болно.

10.2. Бүртгэлийн байгууллага улсын бүртгэлийн дугаарыг өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн 30 хүртэлх хоног төлбөртэй хадгална.

10.3. Автотээврийн хэрэгслийн улсын дугаар хадгалах үйлчилгээний төлбөрийн хэмжээг бүртгэлийн байгууллага тогтооно.

10.4. Бүртгэлийн байгууллага эзэмшигчийн дугаар хадгалах үйлчилгээний хугацаа дуусгавар болж эзэмшигчээс цаашид хадгалалтын хугацааг сунгах хүсэлт гаргаагүй тохиолдолд улсын бүртгэлийн дугаарын санд оруулна.

10.5. Дугаар хадгалахдаа энэхүү журмын 9 дүгээр бүлгийн 9.1.6-т зааснаас бусад баримт бичгийг бүрдүүлж дугаар хадгалах бүртгэлийг баталгаажуулна.

#### **Арван нэг. Автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах**

11.1. Дараах тохиолдолд автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзана:

11.1.1. бүртгэлийн мэдүүлэг болон баримт бичиг нь бүрэн бус, мэдээлэл зөрүүтэй, засварласан;

11.1.2. техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй, хамрагдаагүй;

11.1.3. автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн тухайн жилийн албан татвар төлөөгүй байх;

11.1.4. хуулийн дагуу оногдуулсан торгуулийг төлөөгүй;

11.1.5. зохих байгууллагын зөвшөөрөлгүй зориулалтыг өөрчилсөн;

11.1.6. шилжүүлж буй өмчлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн биеэр ирээгүй;

11.1.7. улсын тэмдэгтийн хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ, үйлчилгээний хөлс төлөөгүй;

11.1.8. эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт хийсэн.

11.2. Бүртгэлийн мэргэжилтэн нь тухайн автотээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэлийг тодорхой тайлбарлан бүртгэлийн мэдүүлэгт тэмдэглэж, гарын үсэг зурж хувийн дугаар бүхий тэмдэг дарна.

#### **Арван хоёр. Бүртгэлийн байгууллага болон бүртгэлийн мэргэжилтний эрх, үүрэг**

12.1. Бүртгэлийн байгууллага нь энэхүү журмын 2-т заасан бүртгэл хөтлөхийн зэрэгцээ бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээ, тайлан гаргах, өмчлөгчтэй холбоотой лавлагаа, мэдээлэл өгөх үйл ажиллагааг хариуцна.

12.2. Бүртгэлийн байгууллагын эрх, үүрэг:

12.2.1. бүртгэлийн байгууллага нь энэхүү журамд заасан бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ нээлттэй, ил тод, авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

12.2.2. тухайн автотээврийн хэрэгслийн түүх агуулсан мэдээллийн сан бий болгож холбогдох улстай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах.

### 12.3. Бүртгэгчийн эрх, үүрэг:

12.3.1.бүртгэлийн мэдүүлэг, автотээврийн хэрэгслийн болон өмчлөгчийн холбогдох баримт бичиг /цаашид “баримт бичиг” гэх/-ийн хамт хүлээн авч иж бүрдэл, мэдээллийн үнэн зөв байдлыг хянах;

12.3.2.тээврийн хэрэгслийн үзүүлэлтийг техник хяналтын үзлэгийн мэдээлэл, техникийн баримт бичигтэй тулган бүртгэх

12.3.3.бүртгэлийн мэдүүлэг, баримт бичиг шаардлага хангаж байгаа бол мэдээллийн санд үнэн зөв оруулах;

12.3.4. бүртгэлийн мэдүүлэг, баримт бичгийг цаасаар болон цахим архив үүсгэн баяжилт хийж архивт хадгалах

12.3.5. автотээврийн хэрэгслийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэхдээ шилжүүлж байгаа өмчлөгч өөрийн биеэр ирсэн, нотариатаар баталгаажсан бүх төрлийн гэрээ хэлцэл, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч, цахим гарын үсэг, цахим хүсэлтийг үндэслэн бүртгэнэ.

12.3.6.автотээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас нэмэлт баримт шаардах;

12.3.7. автотээврийн хэрэгслийн бүртгэлийг хараат бусаар үнэн зөв хөтлөх

12.3.8. автотээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой төрийн болон албаны нууц, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх;

12.3.9. бүртгэлийн мэргэжилтэн нь хүлээн авч бүртгэсэн автотээврийн хэрэгслийн гэрчилгээнд гарын үсэг зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна.

**12.3.10. бүртгэгч нь автотээврийн болон эрх зүйн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, Иргэний хууль болон хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, автотээврийн салбарын стандартчиллын талаар автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдсан байна.**

#### **Арван гурав. Автотээврийн хэрэгсэлд дугаар олгох**

13.1. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 1-р хэсэг. Ерөнхий шаардлага. MNS 4410-1:2002<sup>1</sup> стандартад заасан улсын бүртгэлийн дугаарыг дараах автотээврийн хэрэгсэлд олгоно:

13.1.1.автомашинь энгийн улсын бүртгэлийн дугаарыг дипломат байгууллагын, технологийн, эко болон нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж байгаагаас бусад "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS4598:2011 стандартын 5.8.1, 5.8.2-т заасан зөвшөөрөгдөх үзүүлэлт бүхий авто машинд;

13.1.2.дипломат байгууллагын автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаад улсын элчин сайдын яам, консулын газар Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасан олон улсын байгууллага болон тэдгээрийн дипломат ажилтны хувийн автомашинд;

13.1.3.нийтийн тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг зорчигч тээврийн стандартаар тогтоосон шаардлагуудыг хангасан нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй бүх төрлийн автобус, таксинд;

13.1.4.технологийн тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS4598:2011 стандартын 5.8.1, 5.8.2-т заасан зөвшөөрөгдөх үзүүлэлтээс дээш үзүүлэлт бүхий ачааны автомашин, чиргүүлд;

13.1.5.эко улсын бүртгэлийн дугаарыг цахилгаан, ус төрөгчөөр ажилладаг болон тэдгээрийн хосолмол эх үүсвэрээр ажилладаг хөдөлгүүр бүхий автомашинд;

13.1.6. механизмын улсын бүртгэлийн дугаарыг бүх төрлийн дугуйт трактор, өөрөө явагч машин механизмд;

13.1.7. мотоциклын улсын бүртгэлийн дугаарыг "Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томъёо, тодорхойлолт" MNS ISO 3833:2010 стандартын 3.5-д заасан мотоциклд;

13.1.8. чиргүүлийн улсын бүртгэлийн дугаарыг "Автотээврийн хэрэгсэл. Төрөл, нэр томъёо, тодорхойлолт" MNS ISO 3833:2010 стандартын 3.2-т заасан, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS4598:2011 стандартын 12-т заасан зөвшөөрөгдөх техникийн үзүүлэлт бүхий чиргүүлд тус тус олгоно.

13.2. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ нь "энгийн", "эко", "нийтийн зорчигч тээвэр", "технологийн" гэх мэт улсын бүртгэлийн дугаарын дэвсгэр өнгийг бичих талбартай байна.

13.3. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг монгол, англи хэл дээр хэвлэнэ.

13.4.Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг өмчлөгчийн оршин суух харьяаллын дагуу олгоно.

13.5. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглаж эхлэх болон хасагдах тохиолдолд нийтийн тээврийн үйлчилгээг зохицуулах эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг үндэслэн автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын сери болон тоог өөрчлөхгүйгээр зөвхөн дэвсгэр өнгийг өөрчлөн сольж олгоно.

13.6. Улсын бүртгэлийн дугаар эзэмших эрхийг үнэ хаялцуулах замаар худалдан борлуулж болно. Үнэ хаялцуулах ажиллагааг Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу бүртгэлийн байгууллага холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

13.7.Бүртгэлийн байгууллага нь үнэ хаялцуулах замаар худалдан борлуулах улсын дугаарын жагсаалтыг гаргаж үнэ хаялцуулах худалдаанд оруулах анхны үнийг тогтооно.

13.8.Үнэ хаялцуулах ажиллагааны ялагчтай байгуулсан гэрээг үндэслэн зөвхөн түүний өмчлөлийн тээврийн хэрэгсэлд тухайн дугаарыг олгоно.

13.9. Улсын дугаарыг худалдан борлуулсан орлогыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэг байгуулах, ахмад настны асрамжийн газар байгуулах, өргөтгөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, бизнесийг дэмжих, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай санд төвлөрүүлнэ.

## **Арван дөрөв. Мэдээллийн сан бүрдүүлэх болон цахим үйлчилгээ**

14.1. Мэдээллийн сан нь бүртгэлийн эх баримт бичиг бүхий архив, цахим мэдээллийн сангаас бүрдэх бөгөөд мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглахдаа эрх бүхий байгууллагаас гаргасан төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохицуулсан журам, зааврыг мөрдлөг болгоно.

14.2. Мэдээллийн сан нь төрийн үйлчилгээний нэгдсэн сантай холбогдож энэхүү журмын 14.1 дэх заалтын хүрээнд холбогдон харилцан мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

14.3. Автотээврийн хэрэгслийн талаар бусад төрийн байгууллагуудаас авах мэдээллүүдийг бүртгэлийн байгууллага нь баримтаар шаардахгүй ба төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох журмын хүрээнд цахим сүлжээгээр дамжуулан мэдээллийг авч архивлана.

14.4. Үйлчлүүлэгч өөрийн тоон гарын үсгийг ашиглан цахимаар үйлчилгээ авах нөхцөлийг бүртгэлийн байгууллагаас бүрдүүлж үйлчилнэ.

14.5. Бүртгэлийн цахим үйлчилгээ авах иргэн аж ахуйн нэгж байгууллага нь “Цахим гарын үсгийн тухай” хуулийн дагуу тоон гарын үсэг хэрэглэх гэрчилгээ авсан байна.

14.6. Иргэн, хуулийн этгээд нь өөрийн тоон гарын үсгийг ашиглан төрийн нэгдсэн үйлчилгээний порталаар, эсхүл бүртгэлийн байгууллагын цахим системээр дамжуулан цахим үйлчилгээг авна.

14.7. Цахим үйлчилгээ авахдаа энэхүү журамд заасан бүртгэлийн мэдүүлэг, шаардагдах баримт бичгийн иж бүрдлийг бүрэн хангасан байна.

14.8. Цахимаар үйлчлүүлэгчид автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын бүртгэлийн дугаарын тэмдэгтийг шуудангаар, эсхүл угтах үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчид хүргэж болно.

14.9. Мэдээллийн санд энэхүү журмын хавсралтаар заасан өмчлөгчийн болон техникийн мэдээллийг бүртгэнэ.

14.10. Мэдээллийн санд автотээврийн хэрэгслийн марк, загвар, хөдөлгүүр, арлын дугаарыг латин үсгээр, бусад мэдээллийг кирилл үсгээр бүртгэнэ.

### **Арван тав. Улсын дугаарын үйлдвэрлэл**

15.1. Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг үйлдвэрлэгч /цаашид үйлдвэрлэгч гэх/ нь зохих журмын дагуу авсан тусгай зөвшөөрлийн хүрээнд улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэнэ.

15.2. Үйлдвэрлэгч нь улсын бүртгэлийн дугаарын тэмдэг үйлдвэрлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хүний нөөцөөр бүрэн хангагдсан, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан ажлын байранд үйлдвэрлэлийг эрхэлнэ.

15.3. Улсын бүртгэлийн дугаарыг “Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. 1-р хэсэг: Ерөнхий шаардлага”. MNS 4410-1:2002<sup>1</sup> стандартын үзүүлэлт шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэнэ”,

15.4. Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг үйлдвэрлэгч нь бүртгэлийн байгууллагатай цахим сүлжээгээр холбогдсон байх ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааг цахимаар хянах боломжийг бүрдүүлсэн байна.

15.5. Улсын бүртгэлийн дугаарын тэмдэг үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллага нь холбогдох мэдээ судалгааг бүртгэлийн байгууллагад тухай бүр ирүүлнэ.

15.6. Бүртгэлийн байгууллага нь улсын бүртгэлийн дугаарын бэлдцийн захиалга, нийлүүлэлт, зарцуулалт хяналт тавина.

15.7. Үйлдвэрлэгч нь тусгай зөвшөөрөл олгосон байгууллагатай ажил үүрэг гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллана. Гэрээний зарим заалтын хэрэгжилтийг бүртгэлийн байгууллага хангуулахаар зохицуулж болно.

15.8. Бүртгэлийн байгууллага улсын бүртгэлийн дугаарын үйлдвэртэй байна.?????

### **Арван зургаа. Бусад зүйл**

16.1. Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.

16.2. Бүртгэлийн байгууллага нь автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээг гаргаж автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангана.

16.3. Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, бүртгэлийн мэдүүлэг, хасалтын тодорхойлолт, экспортын сертификатын загварыг батлах, хэвлүүлэх, хадгалах, зарцуулах үйл ажиллагаанд автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

16.4. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----

Зам, тээврийн хөгжлийн сайдын 20 ...  
 оны ....дугаар тушаалаар батлагдсан  
 “Автотээврийн хэрэгслийн бүртгэл  
 хөтлөх, улсын дугаар олгох  
 журам”-ын нэгдүгээр хавсралт

Өмчлөгчийн мэдээлэл

№	Өмчлөгч	Мэдээлэл	
1.	Иргэн	Иргэншил	
2.		Овог	
3.		Нэр	
4.		Регистрийн дугаар	
5.		Хүйс	
6.		Төрсөн огноо	
7.		Оршин суугаа хаяг	
8.		Холбоо барих утас	
9.		Цахим шуудангийн хаяг	
10.	Аж ахуй нэгж, байгууллага	Нэр	
11.		Регистрийн дугаар	
12.		Байгуулагдсан огноо	
13.		Хаяг, байршил	
14.		Цахим шуудангийн хаяг	
15.		Холбоо барих утас	

Зам, тээврийн хөгжлийн сайдын 20 ...  
 оны .....дугаар тушаалаар батлагдсан  
 “Автотээврийн хэрэгслийн бүртгэл  
 хөтлөх, улсын дугаар олгох  
 журам”-ын нэгдүгээр хавсралт

Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн жишиг маягт

Техникийн тодорхойлолт

Гэрчилгээ №	
Улсын дугаар	
Марк	
Загвар	
модификаци	
Төрөл	
Ангилал	
Зориулалт	
Үйлдвэрлэсэн он	
Бүхээг №	

Арал №	
Хөдөлгүүр №	
Хөдөлгүүр V(с.с)	
Өнгө	
Жолооны хурдний байрлал	баруун <input type="checkbox"/> зүүн <input type="checkbox"/>
Хөдөлгүүрийн тэжээлийн эх үүсвэр	
Бензин <input type="checkbox"/>	дизель <input type="checkbox"/>
шахсан хий <input type="checkbox"/>	шингэрүүлсэн хий <input type="checkbox"/>
цахилгаан <input type="checkbox"/>	цахилгаан-бензин <input type="checkbox"/>
Хий-бензин <input type="checkbox"/>	Хий-дизель <input type="checkbox"/>
Устөрөгчийн <input type="checkbox"/>	Бусад <input type="checkbox"/>

Шилжүүлсэн:

Өмчлөгч	Ургийн овог	
	/Эцэг/эх/-ийн нэр/ Байгууллагын нэр	
	Нэр	
	Регистрийн дугаар	
	Хаяг	
	Холбоо барих утас	

Шилжүүлэн авсан:

Өмчлөгч	Ургийн овог	
	/Эцэг/эх/-ийн нэр/ Байгууллагын нэр	



	Нэр	
	Регистрийн дугаар	
	Хаяг	
	Холбоо барих утас	

Шилжүүлсэн:

Шилжүүлэн авсан:

Өмчлөгчийн

Өмчлөгчийн

гарын үсэг.....

гарын үсэг.....

.....он.....сар.....өдөр

Зам, тээврийн хөгжлийн сайдын 20 ...  
оны .....дугаар тушаалаар батлагдсан  
“Автотээврийн хэрэгслийн бүртгэл  
хөтлөх, улсын дугаар олгох  
журам”-ын гуравдугаар хавсралт

Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд  
бүртгэгдэх мэдээллүүдийн жагсаалт

1. Марк
2. Загвар
3. Үйлдвэрлэсэн улс
4. Үйлдвэрлэсэн огноо
5. Импортолсон огноо
6. Арлын дугаар /VIN дугаар/
7. Хөдөлгүүрийн дугаар
8. Өнгө
9. Бүх жин, кг
10. Даац, кг
11. Өөрийн жин, кг
12. Суудлын тоо
13. Хаалганы тоо
14. Оврын хэмжээ, мм, Урт/Өргөн/Өндөр
15. Хүрдний байрлал
  - 15.1. баруун
  - 15.2. зүүн
16. Ангилал
  - 16.1. А ангилал
  - 16.2. В ангилал
  - 16.3. С ангилал

16.4. Д ангилал

16.5. Е ангилал

16.6. Механизм

17. Автотээврийн хэрэгслийн төрөл, зориулалт

17.1. Суудлын автомашин /бүхээгний хэлбэрээр/:

17.2. Автобус

17.2.1. угсраа автобус

17.2.2. том оврын автобус

17.2.3. дунд оврын автобус

17.2.4. бага оврын автобус

17.2.5. троллейбус

17.3. Ачааны автомашин

17.3.1. энгийн тэвштэй ачааны автомашин

17.3.2. эмээлт зүтгүүр

17.3.3. өөрөө буулгагч

17.4. Тусгай зориулалтын ачааны автомашин

17.4.1. автоцистерн нефтийн бүтээгдэхүүний

17.4.2. сүүний

17.4.3. усны

17.4.4. бохирын цооногийн

17.4.5. барилгын зуурмаг тээвэрлэгч

17.4.6. барилгын зуурмаг шахагч

17.4.7. автокран

17.4.8. техникийн түргэн тусламжийн

17.4.9. эмнэлгийн түргэн тусламжийн

17.4.10. гал командын

17.4.11. ахуйн хог хаягдлын

17.4.12. бусад

17.5. Чиргүүл

17.5.1. ачааны автомашины

17.5.2. торхтой чиргүүл

17.5.3. суудлын автомашины

17.5.4. хагас чиргүүл

17.5.5. аяллын зориулалттай чиргүүл

17.5.6. хөргүүр, дулаан тохируулагч бүхий чиргүүл

17.6. Мотоцикл

- 17.6.1. 2 дугуйтай
- 17.6.2. 3 дугуйтай
- 17.6.3. 4 дугуйтай
- 17.6.4. Ачааны мотоцикл
- 17.7. Механизм
  - 17.7.1. дугуйт трактор
  - 17.7.2. өөрөө явагч дугуйт механизм
  - 17.7.3. гинжит трактор
  - 17.7.4. гинжит механизм
- 18. Хөдөлгүүрийн төрөл гэдэгт:
  - 18.1. бензин
  - 18.2. дизель
  - 18.3. хий дизель хосолсон
  - 18.4. цахилгаан-бензин /Хосолсон /гибрид/
  - 18.5. Хий
    - 18.5.1. шингэрүүлсэн нефтийн хий /LPG/
    - 18.5.2. байгалийн шахсан хий -/CNG/-
  - 18.6. Дан цахилгаан
  - 18.7. Устөрөгчийн
  - 18.8. Хөдөлгүүрийн багтаамж, см<sup>3</sup>
- 19. Экологийн ангилал
  - 19.1. евро 0
  - 19.2. евро I
  - 19.3. евро II
  - 19.4. евро III
  - 19.5. евро IV
  - 19.6. евро V
  - 19.7. евро VI
  - 19.8. бусад
- 20. Хурдны хайрцаг
  - 20.1. механик
  - 20.2. автомат
  - 20.3. хосолсон/хагас автомат/
  - 20.4. бусад
- 21. Насжилт /тайлангаар гаргах боломжтой байх/
- 22. Хөтлөгчийн төрөл

- 22.1. урд хөтлөгчтэй,
- 22.2. хойт хөтлөгчтэй,
- 22.3. давхар хөтлөгчтэй,
- 23. Тэнхлэгийн тоо, /тоогоор/

-----00000-----

Зам, тээврийн хөгжлийн сайдын 20 ...  
оны .....дугаар тушаалаар батлагдсан  
“Автотээврийн хэрэгслийн бүртгэл  
хөтлөх, улсын дугаар олгох  
журам”-ын дөрөвдүгээр хавсралт

### Автотээврийн хэрэгслийн гэрчилгээний загвар

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ Technical specifications	MGL	ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА Certificate issuing authority
Улсын бүртгэлийн дугаар Registration plate number	Хөдөлгүүрийн дугаар Engine number	
Марк, загвар Make, model	Үйлдвэрлэсэн он Year of manufacture	
Ангилал, хөдөлгүүрийн багтаамж Category, engine displacement	Импортолсон огноо Date of Importation	Бүртгэлийн ажилтан Registration officer
Бүх жин Gross vehicle weight	Өнгө, Color	Тэмдэг Stamp
Даац, суудлын тоо Loading capacity, number of seats	Тэнхлэгийн тоо Axes	Гарын үсэг Signature
Төрөл Type	Улсын бүртгэлийн дугаарын өнгө Color registration plate number	.....Он..... сар..... өдөр .....YYYY .....MM .....DD
Зориулалт Vehicle designation	Өмчлөгч Owner	Тусгай тэмдэглэл additional note
VIN дугаар, VIN number		.....
Арлын дугаар, Chassis number	Хаяг Address	.....
Бүхээгийн дугаар, Cabin number		.....
	№ 00000000	

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ TECHNICAL INSPECTION			MGL САНАМЖ	МОНГОЛ УЛС MONGOLIA
Он. Сар. Өдөр YYYY.MM.DD	Техникийн байдал Technical status	Гарын үсэг Тэмдэг signature Stamp	<p>АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ӨМЧЛӨГЧ ТА:</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Шинээр автотээврийн хэрэгсэл өмчилж авсан бол 72 цагийн дотор;</li> <li>❖ Ашиглалтаас хассан бол 1 сарын дотор;</li> <li>❖ Нэр, хаяг, арлын болон хөдөлгүүрийн дугаар, өнгө өөрчлөгдсөн бол 7 хоногийн дотор тус тус бүртгүүлэх;</li> <li>❖ Жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдах;</li> <li>❖ Хуульд заасан хугацаанд албан татвараа төлөх;</li> <li>❖ Тогтоосон хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамруулах үүрэгтэй</li> </ul> <p>CERTIFICAT D'IMMATRICULATION DU VEHICULE</p> <p>АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ</p> <p>CERTIFICATE OF VEHICLE REGISTRATION</p> <p>MGL</p> <p>№ 00000000</p>	

Засвартай бол хүчингүй  
Not valid if edited

Зам, тээврийн хөгжлийн сайдын 20 ... оны .....дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын тавдугаар хавсралт

Үнэ хаялцуулан борлуулах улсын дугаарын жишиг жагсаалт

000*, *000 AAAA, 00*0, 0AAA	АВАВ		АВВА		ААВВ	
	0001	0101	5050	0110	5005	0011
0002	0202	5151	0220	5115	0022	5511
0003	0303	5252	0330	5225	0033	5522
0004	0404	5353	0440	5335	0044	5533
0005	0505	5454	0550	5445	0055	5544
0006	0606	5656	0660	5665	0066	5566
0007	0707	5757	0770	5775	0077	5577
0008	0808	5858	0880	5885	0088	5588
0009	0909	5959	0990	5995	0099	5599
1000	1010	6060	1001	6006	1100	6600
2000	1212	6161	1221	6116	1122	6611
3000	1313	6262	1331	6226	1133	6622
4000	1414	6363	1441	6336	1144	6633
5000	1515	6464	1551	6446	1155	6644

6000	1616	6565	1661	6556	1166	6655
7000	1717	6767	1771	6776	1177	6677
8000	1818	6868	1881	6886	1188	6688
9000	1919	6969	1991	6996	1199	6699
1111	2020	7070	2002	7007	2200	7700
2222	2121	7171	2112	7117	2211	7711
3333	2323	7272	2332	7227	2233	7722
4444	2424	7373	2442	7337	2244	7733
5555	2525	7474	2552	7447	2255	7744
6666	2626	7575	2662	7557	2266	7755
7777	2727	7676	2772	7667	2277	7766
8888	2828	7878	2882	7887	2288	7788
9999	2929	7979	2992	7997	2299	7799
0010	3030	8080	3003	8008	3300	8800
0020	3131	8181	3113	8118	3311	8811
0030	3232	8282	3223	8228	3322	8822
0040	3434	8383	3443	8338	3344	8833
0050	3535	8484	3553	8448	3355	8844
0060	3636	8585	3663	8558	3366	8855
0070	3737	8686	3773	8668	3377	8866
0080	3838	8787	3883	8778	3388	8877
0090	3939	8989	3993	8998	3399	8899

Зам, тээврийн хөгжлийн сайдын 20 ...  
оны .....дугаар тушаалаар батлагдсан  
“Автотээврийн хэрэгслийн бүртгэл  
хөтлөх, улсын дугаар олгох  
журам”-ын тавдугаар хавсралт

Үнэ хаялцуулан борлуулах улсын дугаарын жишиг жагсаалт

000*, *000 AAAA, 00*0, 0AAA	АВАВ		АВВА		ААВВ	
	0111	4040	9090	4004	9009	4400
0222	4141	9191	4114	9119	4411	9911
0333	4242	9292	4224	9229	4422	9922
0444	4343	9393	4334	9339	4433	9933
0555	4545	9494	4554	9449	4455	9944
0666	4646	9595	4664	9559	4466	9955
0777	4747	9696	4774	9669	4477	9966
0888	4848	9797	4884	9779	4488	9977
0999	4949	9898	4994	9889	4499	9988

-----ooOoo-----

